

ТАНИЛЦУУЛГА

2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

2023.12-18

Хараат

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон төсвийн байгууллагуудад мэргэжилтнүүдэд хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, 89012150, 75775959 утсаар ажлын цагаар хүлээн авч ажиллаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн ӨГСХ-ийг бүртгэлжүүлэн удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлүүлж, хариуг эзэнд нь утсаар болон албан бичгээр биечлэн уулзаж өгч байна.

2023 оны жилийн эцсээр иргэдээс 117 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд 100 хувийн биелэлттэй шийдвэрлэсэн байна.

Өргөдөл шийдвэрлэхэд зарцуулсан хөрөнгө: Иргэдийн хүсэлт, сумын байгаль орчны байцаагч, багийн Засаг дарга нартай хамтран нохой, муур устгах ажилд 1340000 төгрөгөөр нохой, муурыг устгасан.

Шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдөл хэдэн хувь байсан: Шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдөл байхгүй байна.

Нийт өргөдлийн хэдэн хувийг зэрэгээр шийдвэрлэсэн: 41 иргэний газар эзэмших эрх шилжүүлэх, өвлөж авах, хугацаа сунгах гэрчилгээг цахимд шилжүүлэх гэрчилгээг тус тус шийдвэрлэж газрын кдастрын цахим системд бүртгэж гэрчилгээг бар кодтой болгосон. 4-н багийн 15 иргэнээс малжуулах хүсэлт ирснийг багийн ИНХурлаар хэлэлцэн шийдвэрлэн малжуулсан. Хаягийн тодорхойлолт авах 27 иргэний хүсэлтийн дагуу хаягийн тодорхойлолт гаргаж өгсөн. Байгаль орчинтой холбоотой 25 иргэдийн хог асгуулах, их цэвэрлэгээний ирсэн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Гомдол: нохой, муур устгах, эзэнтэй нохойг уях 6, 1 иргэнээс цэцэрлэгийн хүүхдүүдийн үс бөөстөж байна, 1 иргэнээс 108 утсанд 1 хүүхдийн дээрэлхэлтэд

өртсөн тухай, 1 ажилтанд зан харилцааны талаар нийт 9 иргэнээс ирсэн гомдлыг 100% шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэлтийн дундаж хоногийг тооцоолсон байдал: 1 өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хоног 10 хоногтой байна. Тухайн өргөдлийг шийдвэрлэхэд иргэдээс хөрөнгө, мөнгө хүссэн өргөдөл ирээгүй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
ЗДТГазар	85	0	8	24	55	32	0	0	0
хүүхдийн цэцэрлэг	0	0	0	0	1	0	0	0	0
ЕБСургууль					28				1
бүгд	85	0	8	24	84	32	0	0	1

ЦАГААНДЭЛГЭР СУМ

2022 оны жилийн эцэстэй харьцуулсан дүн

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
ЗДТГазар	0	0	0	238	60	28	0	0	0
нийт				238	60	28			

Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
золбин нохой, муур устгах	6	100%	нохой, муур устгах зар мэдээллийг иргэдэд мэдээлж байна. Иргэдийг нохойгоо уях шаардлагыг тавьж байна.
Цэцэрлэгийн хүүхдүүдийн үс бөөстөж байна.	1	100%	Эцэг эхийн уулзалтыг зохион байгуулж, цэцэрлэгийн эмч сургалт хийж мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Бүлгийн багш нар ариун цэврийг тогтмол үзэж, эцэг эхчүүдэд мэдээлэл өгч байна.
108 утас	1	100%	108 утсанд 1 хүүхдийн дээрэлхэлтэд өртсөн дуудлага бүртгэгдсэн ба хүүхдийн зан төлөв, дээрэлхэлтээс сэргийлэх, үе тэнгийнхнээ хүндлэх ганцаарчилсан ярилцлага, сургалт, эцэг эхтэй хамтарсан ярилцлага, зөвлөгөө зэрэг үйл ажиллагаа явуулж, кэйсийг хаасан тайланг аймгийн ГБХЗГ руу илгээсэн.
Зан харилцаа	1	100%	1 ажилтанд зан харилцааны гомдол гарсныг ЗДЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвлөгөө, сануулга өгч шийдвэрлэсэн. Дахин гомдол гараагүй.
Нийт	9	100%	Санал, хүсэлт, гомдлыг холбогдох хууль, журмын дагуу 100% шийдвэрлэсэн.